



ДАРХАН-УУЛ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠒ сарын ᠒᠒ өдөр

Дугаар ᠐1-А/43

Дархан

Согтууруулах ундаа худалдах, түүгээр  
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.7, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.3, 10.1.5, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 14.2, 16 дугаар зүйлийн 16.2.5, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 10/04 дүгээр тогтоолоор батлагдсан “Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 2 аж ахуйн нэгж байгууллага, үйл ажиллагаа нь зогссон тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох 1 аж ахуйн нэгж байгууллагын нэрсийг тус тус хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл шинээр олгох “Золоо хүү” ХХК, “ХДА” ХХК аж ахуйн нэгжийн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр тогтоосугай.

3. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийн талаар шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор аймгийн Татварын хэлтэс болон тусгай зөвшөөрөл эзэмшигчид бичгээр мэдэгдэхийг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтийн дарга (П.Батсүх)-д үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Жавхлан), Дархан сумын Засаг дарга (Т.Тулгаа), Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Д.Ганзориг), Онцгой байдлын газар (хурандаа С.Пүрэвсамдан), Мэргэжлийн хяналтын газар (Д.Бат-Эрдэнэ), Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Б.Цэвээндорж), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Ганболд), Татварын хэлтэс (Х.Оюунцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б. АЗЖАРГАЛ



4522010106

Аймгийн Засаг даргын оны 2022 он  
 02 сарын 02-ний өдрийн 01-А/43  
 дугаар захирамжийн хавсралт



**СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР  
 ОЛГОХ, ЦУЦЛАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ**

№	Аж ахуйн нэгжийн нэр	Үйлчилгээний газрын нэр	Регистр	Хаяг, байршил	Захирлын нэр, утас
<b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ</b>					
1	Дархан цоморлиг ХХК	Дархан цоморлиг дэлгүүр	2775492	Дархан сум, 14-р баг 3-р байр 1 тоот	Ж.Оюун 9937-4383
<b>ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ</b>					
2	ХДА ХХК	Тод бэх хүнсний дэлгүүр	4258479	Дархан сум, 5-р баг Хүнсчид 2-7 тоот	Б.Дөлгөөн 8808-6670
3	Золоо хүү ХХК	Оч хүнсний дэлгүүр	4288009	Дархан сум, 16-р баг 1-р хороолол 17-43 тоот	Ө.Нэргүй 9478-1717